# “СИ ЭС АЙ АУДИТ” ХХК

2019 оны 6 сарын 12

№ 18/165

"Булган ундарга" ХХК-*ийн*
*Захирал* Ц.Батаа *танаа*

*Хүлээн авагчийн нэр "Булган ундарга" ХХК*
**Хамрагдсан хугацаа:** *2018 оны12 сарын 31*

**Хараат бус аудиторын дүгнэлт**

Бидний дүгнэлтээр "Булган ундарга" ХХК-ийн 2018 оны 12 сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулга нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

**Үндэслэл**

Бид "Булган ундарга" ХХК-ийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад санхүүгийн тайлангийн аудит хийсэн.

**Санхүүгийн тайланд удирдлагын хүлээх хариуцлага:**

Санхүүгийн тайлангуудыг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэж танилцуулах нь байгууллагын гүйцэтгэх удирдлагын хүлээх хариуцлага юм.

Энэхүү санхүүгийн тайлангуудыг залилан болон алдааны улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллээс ангид буюу үнэн бодитойгоор бэлтгэх, дотоод хяналтын системийг бий болгох, тууштай ажиллуулах, нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, тухайн нөхцөл байдалд тохирох нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг үнэн зөв бодитой бэлтгэгдсэн эсэхийн хариуцлагыг байгууллагын удирдлага хүлээнэ.

**Аудиторын хүлээх хариуцлага:**

Гүйцэтгэсэн аудитынхаа үр дүнд тулгуурлан санхүүгийн тайланд дүгнэлт гаргах нь бидний үүрэг болно.

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэдэг.

Эдгээр стандарт нь аудитороос мэргэжлийн болон ёс зүйн зарчмуудыг баримтлах, санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаа зөрчилгүй илэрхийлэгдсэн хангалттай бөгөөд үндэслэлтэй магадлагаа олж авах зорилгоор аудитыг урьдчилан төлөвлөж, тохиромжтой горимуудыг хэрэглэн баталгаажуулалтыг гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын арга горимуудыг санхүүгийн мэдээллийн боловсруулалт, тайлагналын байдалд нийцүүлэн аудитор өөрийн шийдлээр сонгож хэрэглэдэг бөгөөд алдаа эсвэл залилангийн улмаас гарч болох материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийн судалгаа, тооцооллууд үүнд багтдаг.

Эрсдэлийн судалгаа үнэлгээг компанийн дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг сонгон хэрэглэхийн тулд ашигладаг.

Аудитор нь үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтыг судлан үзэж удирдлагын хийсэн томоохон дүн бүхий тооцооллууд, хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогод үндэслэн санхүүгийн тайланд үнэлэлт өгдөг.

Гүйцэтгэсэн аудитын үр дүнд олж тогтоосон зүйлүүд ба тэдгээрт холбогдох баримт мэдээллүүд нь санхүүгийн тайлангийн талаархи дүгнэлт саналыг гаргахад хангалттай бөгөөд зохистой нотолгоо болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,

СИ ЭС АЙ

ЗАХИРАЛ М.СЭВЖИДМАА